# МОНГОЛ УЛСЫН
# УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 27 өдөр Дугаар А/18 Улаанбаатар хот

Худалдан авах ажиллагааны
төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/299 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний ерөнхий төлөвлөгөөний 1.6-д батлагдсан Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд тусгагдсан 334,000,000.0 төгрөгийг 45,567,680.0 төгрөгөөр бууруулж 288,432,320.0 төгрөгөөр, уг төлөвлөгөөний 1.7-д Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний яам агентлагийн үйлчилгээний чанар, хүртээмжид хэрэглэгчийн үнэлгээ хийх ажлыг 12,000,000.0 төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр, 1.8-д Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2020 оны буюу 15 дугаар нэгтгэл тайлан боловсруулах, цахим тайлангийн мэдээллийг сайжруулах, чадавхи хэрэгцээг судлах зөвлөх үйлчилгээний ажлыг 90,000,000.0 төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр нэмж тусган өөрчилж, хавсралтаар баталсугай.

2. Ашигт малтмал, газрын тосны газрын 2021 онд улсын төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээг 17,224,700.0 төгрөгөөр бууруулж 185,875,300.0 төгрөгөөр, Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих хөрөнгөөр санхүүжүүлэх 675,000,000.0 төгрөгийн 6 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээг уг жагсаалтын 2.1-2.6-д нэмж тусган тус тус баталсугай.

3. Батлагдсан төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж, тайлагнахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн, Үндэсний геологийн албаны дарга О.Чулуун нарт даалгасугай.

4. Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Одхүү/-т үүрэг болгосугай.

5. Энэ тушаалыг гарсантай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/300 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЁНДОН

08 0040

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 27 -ны өдрийн А/18 дугаар тушаалын хавсралт

# УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН 2021 ОНД ХУДАЛДАН АВАХ БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Тухайн жилд худалдан авах бараа,ажил үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал | Батлагдсан төсөвт өртөг /сая төгрөг/ | Тухайн онд санхүүжих /сая төгрөг/ | Эрх шилжүүлэх эсэх /ТЕЗ-ийн нэр/ | Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журам | Худалдан авах ажиллагаанд мөрдсөн хугацаа: Үнэлгээний хороо байгуулах огноо | Тендер зарлах огноо | Гэрээ байгуулах эрх олгох огноо | Гэрээ дуусгавар болох, дүгнэх огноо | Тайлбар тодруулга |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| I | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | | | | | | | | | |
| | **Урсгал зардал** | | | | | | | | | |
| | **Хангамж, бараа материалын зардал** | | | | | | | | | |
| 1.1 | Бичиг хэрэг | 28.40 | 28.40 | УУХҮЯ | ХА | 2020.12.18 | 2021.01.20 | 2021.01.28 | 2021.12.21 | |
| 1.2 | Тээвэр, шатахуун | 17.91 | 17.91 | УУХҮЯ | ХА | 2020.12.18 | 2021.01.14 | 2021.01.25 | 2021.12.21 | |
| 1.3 | Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс | 25.64 | 25.64 | УУХҮЯ | ХА | 2020.12.18 | | | 2021.12.21 | Тухай бүр худалдан авалтыг хийнэ. |
| | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | | | | | | | | |
| 1.4 | Багаж, техник, хэрэгсэл | 49.50 | 49.50 | УУХҮЯ | ХА | 2020.12.18 | | | 2021.12.21 | Тухай бүр худалдан авалтыг хийнэ. |
| | **Геологийн байгууллага** | | | | | | | | | |
| 1.5 | Геологи хайгуул, судалгааны ажил | 29,178.33 | 5,203.76 | УУХҮЯ | НТШ | 2021.01.06 | 2021.02.20 | 2021.05.25 | 2024.12.21 | Жагсаалтыг УУХҮ-ийн сайдын тушаалаар батлана. |
| | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ** | | | | | | | | | |
| 1.6 | Эрдэм шинжилгээ, судалгааны ажил | 288.43 | 288.43 | УУХҮЯ | Зөвлөх сонгох бага үнийн арга | 2021.01.13 | 2021.02.08 | 2021.03.20 | 2021.10.02 | Жагсаалтыг УУХҮ-ийн сайдын тушаалаар батлана. |
| 1.7 | УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний яам агентлагийн үйлчилгээний чанар, хүртээмжид хэрэглэгчийн үнэлгээ хийх | 12.00 | 12.00 | УУХҮЯ | ХА | 2021.01.28 | 2021.02.15 | 2021.02.22 | 2021.04.10 | |
| 1.8 | Монгол Улсын ОҮИТБС-ын 2020 оны буюу 15 дугаар нэгтгэл тайлан боловсруулах, цахим тайлангийн мэдээллийг сайжруулах, чадавхи хэрэгцээг судлах зөвлөх үйлчилгээ | 90.00 | 90.00 | УУХҮЯ | НТШ | 2021.02.15 | 2021.03.01 | 2021.06.01 | 2021.12.21 | |
| | **Нийт дүн** | **29,690.21** | **5,715.64** | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| II | **Ашигт малтмал, газрын тосны газар** | | | | | | | | |
| 1 | **Урсгал зардал** | | | | | | | | |
| **Хангамж бараа материалын зардал** | | | | | | | | | |
| 1.1 | Принтерийн хор | 9.6 | 9.6 | АМГТГ | ШХА | | | | | Тухай бүр захиалгын дагуу худалдан авалт хийнэ. |
| 1.2 | Бичиг хэргийн материал | 9.5 | 9.5 | АМГТГ | ШХА | | | | | Тухай бүр захиалгын дагуу худалдан авалт хийнэ. |
| 1.3 | Плоторын цаас | 2.5 | 2.5 | АМГТГ | ШХА | | | | | Тухай бүр захиалгын дагуу худалдан авалт хийнэ. |
| 1.4 | Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс | 14.9 | 14.9 | АМГТГ | ШХА | | | | | Тухай бүр захиалгын дагуу худалдан авалт хийнэ. |
| 1.5 | Шатахуун | 58.4 | 58.4 | АМГТГ | НТШ | 2021.03.05 | 2021.03.24 | 2021.05.10 | 2021.12.24 | |
| | **Дүн** | **94.9** | **94.9** | | | | | | | |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | | | | | | | | | | |
| 1.6 | Багаж техник хэрэгсэл | 9.50 | 9.50 | АМГТГ | ШХА | | | | | Тухай бүр захиалгын дагуу худалдан авалт хийнэ. |
| 1.7 | Урсгал засвар үйлчилгээ | 4.4 | 4.4 | АМГТГ | ШХА | | | | | Тухай бүр захиалгын дагуу худалдан авалт хийнэ. |
| | **Дүн** | **13.9** | **13.9** | | | | | | | |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ** | | | | | | | | | | |
| 1.8 | Харуул хамгаалалтын хөлс | 44.4 | 44.4 | АМГТГ | ХА | 2021.02.01 | 2021.02.22 | 2021.04.07 | 2022.04.30 | 1.Техник үйлчилгээний төв 2.УУГТТЛ-ийн байр |
| 1.9 | Даатгалын үйлчилгээ /2 багц/ | 32.6 | 32.6 | АМГТГ | ХА | 2021.03.05 | 2021.04.21 | 2021.06.03 | 2022.07.30 | 1. Тээврийн хэрэгслийн даатгал 2. Хөдөлмөрийн чадвар түр алдалт болон гэнэтийн ослын даатгал |
| | **Дүн** | **77.1** | **77.1** | | | | | | | |
| | **Дүн /урсгал зардлаас/** | **185.9** | **185.9** | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | **Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгийн хөрөнгө** | | | | | | | | |
| 2.1 | Геофизикийн чичирхийллийн судалгааны соронзон хальс уншигч тоног төхөөрөмж | 350.0 | 50.0 | АМГТГ | ХА | 2021.04.23 | 2021.05.20 | 2021.06.21 | 2021.12.30 | Уг ажлыг 2 үе шаттайгаар 2019-2020 онд зохион байгуулсан бөгөөд 2019 онд 159.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд 2020 онд хойшлуулан 2021-2022 онд хэрэгжүүлэхээр болсон. |
| 2.2 | Шатахуун октан тодорхойлогч УИТ-85М багажны оношилгоо, тохиргоо, засвар, үйлчилгээ | 50.0 | 50.0 | АМГТГ | ХА | 2021.04.23 | 2021.05.20 | 2021.06.30 | 2021.12.30 | |
| 2.3 | Туулах чадвар сайтай 2 ширхэг автомашин худалдан авах | 470.0 | 470.0 | АМГТГ | НТШ | 2021.01.20 | 2021.01.29 | 2021.03.15 | 2021.12.30 | Төрийн өмчийн, бодлого зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 728 дугаар тогтоолын дагуу 2 автомашин худалдан авах. |
| 2.4 | Компьютер, принтер болон бусад техник хэрэгсэл | 70.0 | 70.0 | АМГТГ | НТШ | 2021.04.23 | 2021.05.20 | 2021.07.20 | 2021.12.30 | |
| 2.5 | Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөлтэй холбогдуулан байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэх | 20.0 | 20.0 | АМГТГ | ЗҮ бага үнийн арга | 2021.02.20 | 2021.03.15 | 2021.04.15 | 2021.12.30 | |
| 2.6 | Төрийн байгууллагаас үзүүлж байгаа цахим үйлчилгээ болон мэдээллийн технологийн дэд бүтцэд аудитын эрх бүхий этгээдээр үнэлгээ хийлгэх | 15.0 | 15.0 | АМГТГ | ЗҮ бага үнийн арга | 2021.02.20 | 2021.03.15 | 2021.04.15 | 2021.12.30 | |
| | **Дүн /ТГҮАДХ-ээс/** | **975.0** | **675.0** | | | | | | | |
| | **Нийт дүн** | **1,160.9** | **860.9** | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| III | **Үндэсний геологийн алба** | | | | | | | | | |
| 1 | **Урсгал зардал** | | | | | | | | | |
| **Хангамж бараа материалын зардал** | | | | | | | | | | |
| 1.1 | Бичиг хэрэг | 7.5 | 7.5 | ҮГА | ШХА | | | | | Тухай бүр захиалгын дагуу худалдан авалт хийнэ. |
| 1.2 | Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс | 4.6 | 4.6 | ҮГА | ШХА | | | | | Тухай бүр захиалгын дагуу худалдан авалт хийнэ. |
| 1.3 | Шатахуун | 9.8 | 9.8 | ҮГА | ШХА | | | | | Тухай бүр захиалгын дагуу худалдан авалт хийнэ. |
| | **Дүн** | **21.9** | **21.9** | | | | | | | |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ** | | | | | | | | | | |
| 1.4 | Харуул хамгаалалтын хөлс | 30.0 | 30.0 | ҮГА | ХА | 2021.01.11 | 2021.01.25 | 2021.04.01 | 2022.04.01 | ҮГА-ны төв байр |
| 1.5 | Даатгалын үйлчилгээ | 10.0 | 10.0 | ҮГА | ШХА | | | | | 1. Тээврийн хэрэгслийн даатгал,<br>2. Хөдөлмөрийн чадвар түр алдалт болон гэнэтийн ослын даатгал |
| | **Дүн** | **40.0** | **40.0** | | | | | | | |
| | **Нийт дүн** | **61.9** | **61.9** | | | | | | | |
| | **Нийт худалдан авалтын дүн** | **30,913.0** | **6,638.4** | | | | | | | |